



13

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 18

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.8.а, 5.11 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

- Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1,433,544 /нэг сая дөрвөн зуун гучин гурван мянга таван зуун дөчин дөрөв/ төгрөгийн анхны өртөгтэй элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нэхсэн Наран багийн склад, 592,116 /таван зуун ерэн хоёр мянга нэг зуун арван зургаа/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нэхсэн моторын гражыг амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд хүсэлт гаргасан тохиолдолд үнэ төлбөргүй олгохыг зөвшөөрсүгэй.
- Баянжаргалан сумын ИТХ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14,493,270 /арван дөрвөн сая дөрвөн зуун ерэн гурван мянга хоёр зуун дал/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртөгөө нэхсэн Дуя 41-89 улсын дугаартай Isuzu Bighorn автомашин болон Сум дундын Шүүхийн шийтгэх тогтоолоор орон нутгийн орлого болгохоор шийдвэрлэгдсэн Дуя 56-42 улсын дугаартай Excel маркын автомашиныг хавсралтын дагуу худалдан авах хүсэлт гаргасан хүнд шууд худалдсугай.
- Актлагдсан болон худалдагдсан хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Оюунчимэг, Баянжаргалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Батбилэг нарт даалгасугай.
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 сарын 21—ний өдрийн 270 тоот “Хөрөнгө дахин үнэлж худалдах тухай” тогтоол, 2014 оны 12 сарын 18-ны өдрийн 285 тоот “Үнэлгээ тогтоох тухай” тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.
- Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.



С.БУДЖАВ

0100045

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 04 сарын  
12-р тогтоолын хавсралт

Тээврийн хэрэгслийн худалдах үнэ

| №          | Хөрөнгийн нэр          | Тээврийн хэрэгслийн марк | Улсын дугаар | Үйлдвэрлэсэн он | Худалдах үнэ   |
|------------|------------------------|--------------------------|--------------|-----------------|----------------|
| 1          | Баянжаргалан автомашин | Isuzu Big horn           | Дуа 41-89    | 2001            | 500,000        |
| 2          | Автомашин              | Excel                    | Дуа 56-42    | 1991            | 100,000        |
| <b>ДҮН</b> |                        |                          |              |                 | <b>600,000</b> |